



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 602

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг тус тус үндэслэн Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2019 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 10.2 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтын байдалд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Б.Галбадрахад дотоод хяналтыг зохион байгуулж, тайлан дахь зөвлөмж болон дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах;

2.2. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллах;

2.3. Төрийн байгууллагын эзэмшил дэх авто зам, зогсоолын талбайд зогсоол ажиллуулах, үйлчилгээ эрхлэгчийн сонгон шалгаруулалтын асуудлыг зохих хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх арга хэмжээ авах;

2.4. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн хойд талд байрлалтай, байгууллагын эзэмшил дэх газрыг ашиглаж буй этгээдтэй ашиглалтын гэрээ байгуулж ажиллах;

2.5. Шалгалтын тайландаа дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 08.-ны өдрийн
602 дугаар тогтоолын хавсралт

Гэмтэл согог судлалын үндэсний төвд хийсэн ~~шалгалтаар илэрсэн~~
зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн /сая төгрөг/	Зөрчигдсөн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Төрийн байгууллагын эзэмшил дэх авто зам, зогсоолын талбайд зөвшөөрөлгүй төлбөрт үйлчилгээ зохион байгуулсан	10.2	Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 102, 119, 2018 оны 59, 293, 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоол	ТӨБЗГ-ын тогтоол шийдвэрийг мөрдөж ажиллах
2	Байгууллагын эзэмшил дэх газрыг бусдад гэрээгүй ашиглуулсан	-	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 27 дугаар зүйл	Ашиглалтын гэрээ байгуулж ажиллах
НИЙТ ДҮН:		10.2		